БАТЛАВ
"ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН"
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
............................/ Ц.АМАРЗАЯА/

БАТЛАВ
"ДАРХАН СЕКЬЮРИТИ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
............................/Д.ЭНХМАА/

# ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 18 өдөр №  Дархан-Уул аймаг

## Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээг нэг талаас "Дархан Секьюрити" ХХК (УБД: 1911050690, РД: 2775336 Харуул хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар: 20220360001 тоот.) түүнийг төлөөлж **ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭНХМАА** /цаашид "үйлчлэгч" тал гэх/ нөгөө талаас **Нягтлан бодогч Д.Цогбаяр** /цаашид "үйлчлүүлэгч" тал гэх, хамтад нь талууд гэх/ нар харилцан тохиролцож үйлчлэгч тал нь үйлчлүүлэгч талын **Дархан сумын багын төвүүд** обьектод дохиолол хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх зорилгоор дараах нөхцөлтэйгээр байгуулав.

1.1 Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана.
1.2 Талууд бие биенийхээ ашиг сонирхлыг хүндэтгэн, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, албаны болон хувь хүний нууцлалыг чанд хадгалах, харилцан ойлголцох зарчмуудыг баримталж ажиллана.

## Хоёр. Гэрээний хугацаа, төлбөр

2.1 Үйлчлэгч нь үйлчлүүлэгч талын "Дархан сумын багын төвүүд"-ийн обьектод 2025 оны 03 сарын 18 –ны өдрөөс эхлэн дохиоллын тоног төхөөрөмж суурилуулан удирдлагын төв пультэд холбож,түүний засвар үйлчилгээ, техникийн хэвийн ажиллагааг хангаж, хамгаалж, хамгаалуулж ажиллахаар харилцан тохиролцов.
2.2 Тухайн обьектын дохиолол хамгаалалтын үйлчилгээний сарын төлбөр НӨАТ-тэйгээр нийт **2,450,000** төгрөг байна. Төлбөрийг 2025 оны 03-р сараас эхлэн сар бүрийн 21-ны дотор ХААН банкны "Дархан Секьюрити" ХХК-ийн 5045169968 тоот дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлэх ба сарын үйлчилгээний төлбөрт үйлчлэгч талыг пультэнд холбох нэг удаагийн төлбөр, тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хөлс орохгүй бөгөөд сарын төлбөр нь үйлчлэгч талаас үзүүлж буй зөвхөн дохиолол хамгаалалтын төв ба шуурхай хэсгийн үйлчилгээний хөлс гэж талууд тохиролцов.
2.3 Үйлчлүүлэгч талаас энэхүү гэрээний 7.3-д заасан зөрчлийг тухайн сард 2 ба түүнээс дээш удаа гаргасан тохиолдолд зөрчлийн актыг үндэслэн хуурамч дуудлага тус бүрд 5000 төгрөгийн торгууль тавигдана.
2.4 Хөлсийг тохирсон хугацаанд төлөөгүй бол хоног тутамд уг үнийн дүнгийн 0,1%-ийн алданги төлнө. Төлбөрийн хугацаа 14 хоногоос хэтэрсэн тохиолдолд гэрээний 13.15-г хамгаалагч тал хэрэгжүүлнэ.
2.5 Гэрээг 2025 оны 03 -р сарын 18-ны өдрөөс эхлэн 2025 оны 12-р сарын 31-ны өдрийг дуустал байгуулав.
2.6 Аль нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд талууд урьдчилан нэг сарын өмнө бичгээр мэдэгдэнэ.
2.7 Дохиоллыг өөрсдийн хүсэлтээр тухайн үед хаалгаж болох ба энэ тухайгаа төв пультруу утасдаж албан ёсоор мэдэгдэнэ.
2.8 Дохиоллын тоног төхөөрөмжинд 1 жилийн баталгаат хугацаа өгнө.

## Гурав. Нэр томъёоны ойлголт

3.1 Обьект гэдэг эрх зүйн хувьд Үйлчлүүлэгч талын "Дархан сумын багын төвүүд"-ын обьектыг бүхэлд нь ойлгоно. /цаашид обьект гэх/
3.2 Дохиолол хамгаалалтын техник хэрэгсэл гэдэгт обьектод угсарч суурилуулан, тохиргоо хийж ажиллагаанд оруулсан Үйлчлүүлэгчийн хууль ёсны өмчлөл, эзэмшил аль эсхүл түрээсийн журмаар тавигдсан дохиолол хамгаалалтын системийг ойлгоно.
3.3 Дохиоллын Мэдээлэл Боловсруулах Төв гэдэгт Үйлчлүүлэгчийн дохиолол хамгаалалтын системээс түгшүүрийн дохио хүлээн авдаг, Үйлчлэгчийн өмчлөлд буй компьютерийн сүлжээ бүхий дохиолол хамгаалалтын төвийг ойлгоно. /цаашид Дохиоллын МБТөв гэх/
Шуурхай бүлэг гэдэгт Дохиоллын МБТөвийн оператор түгшүүрийн мэдээг хүлээн авмагц уг обьект руу явуулж шалгуулдаг машинтай хамгаалалтын хэсгийг ойлгоно.
3.4 Итгэмжлэгдсэн төлөөлөгч гэдэгт үйлчлүүлэгч талаас томилогдсон тухайн обьектийг дохиололд өгч хаах, нээх эрхтэй субьектийг ойлгоно. /цаашид итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх/

3.5 Захиалгын хуудас гэдэгт Обьектийг төв пультэд холбох бүх нөхцлийг заасан техникийн дүгнэлт, тоноглолын план зураг бүхий хуудсыг ойлгоно. /захиалгын хуудас нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй/

**Дөрөв. Обьектийн бэхжилтэд тавих шаардлага**

4.1 Хамгаалж буй обьектийн хана, тааз, шал гаднаас нэвтрэх боломжгүй байх, хаалга, цонх, шалны болон дээврийн нээлхий нь бат бөх хийгдсэн, түгжээ, цоож, бэхэлгээтэй /төмөр решотка/ байх

4.2 Хамгаалуулж байгаа обьектийн дотор байгаа мөнгөн тэмдэгт, үнэт цаас, үнэт эдлэл, бичиг баримтыг зориулалтын бөх бат сейф, саванд хийж хадгалах

**Тав. Дохиолол хамгаалалтын үйлчилгээ эхлэх нөхцөл**

5.1 Үйлчлүүлэгч талаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ гэрээ болон байгууллагынхаа дотоод журмын дагуу обьектийг хамгаалалтанд өгөх ба нээх.

5.2 Итгэмжлэгдсэн төлөөлөгч үйлчлэгч талын харуул хамгаалалтын албан хаагчид мэдэгдэн хамгаалалтанд өгч дохиоллын систем МБТөвд холбогдсон цаг минутаас эхлэн Үйлчлүүлэгчийг нээх хугацаанд Үйлчлэгч хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.

**Зургаа. Түгшүүр хүлээн авсны дагуу явуулах үйл ажиллагаа**

6.1 Обьектод халдлага, галын аюул гарсан, гадны этгээд оьектод нэвтэрснийг заасан дохиог дохиоллын МБТ-д хүлээн авмагц оператор шуурхай хэсгийг обьект руу илгээж, хэрэглэгч рүү утасдан дуудаж шалтгааныг тодруулна.
Шуурхай хэсэг түгшүүрийн дохио ирсэн обьектод очиж дохиолол ажилласан шалтгааныг тогтоох зорилгоор гаднах үзлэгийг обьектод нэвтрэн оролгүйгээр хийнэ.

6.2 Болсон явдлыг үйлчлүүлэгчид мэдэгдэх ба үйлчлүүлэгчийн обьектод нэвтэрсэн, хохирол учирсан, эвдэж орсон, эвдэж орохыг завдсан, ул мөр илэрхий байвал цагдаагийн байгууллага, гал команд, түргэн тусламжийн аль шаардлагатайд яаралтай мэдэгдэнэ.

6.3 Дохиолол хамгаалалт бүхий обьектод гэмт халдлага үйлдэгдсэн тохиолдолд тухайн обьектийн дарга, эзэн буюу итгэмжлэгдсэн төлөөлөгч цагдаагийн байгууллагын ажилтан иртэл уг обьектийг хамгаалалтанд авч аюулгүй байдлыг хангана.

**Долоо. Аюулын товчлуурын дуудлага хүлээн авах, явуулах үйл ажиллагаа**

7.1 Үйлчлэгч тал нь үйлчлүүлэгч талтай харилцан зөвшилцөж аюулын товчлуурын шаардлагатай үед цаг алдалгүй дарж мэдээ дамжуулах байрлалд, ажилтнуудад хүрэлцэхүйц хэмжээтэйгээр байрлуулна. Цаашид гар удирдлагаар хангаж тухайн ажилтнуудад халдлага гарах үед аюулгүйн товчлуурыг дарж хэвших сургалтыг зохион байгуулна.

7.2 Үйлчлүүлэгч аюулын товчлуурыг дараах нөхцөлд ашиглана.
  a. Гэмт этгээд халдсан, халдахыг завдсан
  b. Зэвсэглэсэн этгээд халдсан, халдахыг завдсан
  c. Мөнгө, төгрөг үнэт зүйлсийг хулгайлсан, хулгайлахыг завдсан буюу авахыг шаардан заналхийлсэн

7.3 Үйлчлүүлэгч товчлуурыг дараах нөхцөлд ашиглахгүй
  a. Үйлчлэгч, хэрэглэгч болон ажилтнуудын хооронд хөдөлмөрийн болон ахуйн шинжтэй хэв журмийн маргаан үүссэн гэх зэрэг тохиолдолд

**Найм. Итгэмжлэгдсэн төлөөлөгч**

8.1 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үйлчлүүлэгч талын захиргаа тогтооно.

8.2 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нууц код эзэмшиж, обьектийг нээж, хаах үйлдлийг гүйцэтгэнэ.

8.3 Итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн хаяг болон холбоо барих утсыг үйлчлүүлэгч талд тэмдэглүүлж, гэрээний 8-д заасан эрх үүргийг эдлэнэ.

8.4 Обьектийг хамгаалалтанд өгөхдөө Итгэмжлэгдсэн төлөөлөгч Үйлчлэгчийн хамгаалалтын ажилтанд мэдэгдэх ба хамгаалалтанд авагдсан талаар лавлаж, заавал хариу авсны дараа обьектоос буунa.

8.5 Обьектийн дохиололд гарсан өөрчлөлтийн талаар Итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдсэн тохиолдолд Итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр ирэх үүрэгтэй.

8.6 Обьектын дохиолол ажилласан үед хаалт хийсэн Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо барина. Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбогдох боломжгүй үед дараагийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид хэлэх арга хэмжээ авна.

8.7 Цахилгаан тасарч батерей суух үед Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг дуудаж батерей солих арга хэмжээг яаралтай авах ба Итгэмжлэгдсэн төлөөлөгч ирээгүйн улмаас тоног төхөөрөмж мэдээлэл дамжуулах боломжгүй болох, телефон утас ажилгүй болох, обьект дохиололд холбогдоогүйг Итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдсээр байтал ирээгүйн улмаас учирсан хохирлыг үйлчлэгч тал хариуцахгүй байж болох бөгөөд өөрийн зүгээс боломжтой арга хэмжээг авна. Батерейг 12сар ашиглаад солино.

8.8 Үйлчлүүлэгч тал обьектийг дохиоллын хамгаалалтанд өгөх үед тоног төхөөрөмж Дохиоллын МБТ-д холбогдох боломжгүй бол Үйлчлэгч тал обьектийн харуул хамгаалалтаа зохион байгуулах арга хэмжээг авна.

8.9 Итгэмжлэгдсэн төлөөлөгч обьектийг хамгаалалтанд өгөлгүйгээр орхиж явснаас үйлчлүүлэгч талд хохирол учирвал үйлчлэгч тал хариуцлагаас чөлөөлөгдөнө.

8.10 Обьектонд гэрээнд заасанаас бусад цагт нэвтэрсэн бүх тохиолдолд үйлчлэгч тал нэвтрэх үг /нууц үг/ авна.

8.11 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оршин суух хаяг өөрчлөгдөх, амралтын болон баяр ёслолын өдрүүдэд өгсөн хаягандаа байхгүй тохиолдолд энэ талаар Дохиоллын МБТөвд мэдэгдэн тэмдэглүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллана.

8.12 Итгэмжлэгдсэн төлөөлөгч ажлаас халагдсан тохиолдолд нууц үг, кодыг даруй өөрчилж, түүнийг орлох төлөөлөгчийг нэн даруй томилохыг үйлчлүүлэгчээс шаардах эрхтэй.

**Ес. Дохиоллын МБТөвийн оператор**

9.1 Оператор нь дохиолол хамгаалалтын компьютерт байгаа мэдээллийг байнга хянаж түгшүүрийн дохиог хүлээн авмагц шуурхай бүлэгт мэдэгдэж обьект руу яаралтай очиж шалгахыг шаардана.

9.2 Обьект хаах цагтаа хаагаагүй тохиолдолд энэ тухай тодруулах ба нээх цагаас бусад үед обьект руу хүн нэвтэрсэн тохиолдол бүрт утасдаж нууц үгийг асууж харьцана.

9.3 Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгч обьектийг дохиоллын хамгаалалтанд өгөөгүй явсан нь тогтоогдвол энэ тухай өөрт нь яаралтай мэдэгдэж, обьектийг хамгаалалтанд өгөхийг шаардаж, хамгаалалтанд авна.

9.4 Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо барих боломжгүй бол энэ тухай тус үйлчлүүлэгчийн удирдлагад яаралтай мэдэгдэн арга хэмжээ авахуулна.

9.5 Обьектод гадны халдлага болох, галын аюул учрах тохиолдолд эмнэлэг, цагдаа, галын байгууллагад яаралтай мэдэгдэж, өөрийн компаний ерөнхий жижүүр, тасгийн дарга болон шаардлагатай гэж үзвэл удирдлагад мэдэгдэнэ.

9.6 Үйлчлүүлэгчийн объектод 2-с дээш буюу зоон дамжиж утаа мэдрэгч ажилласан тохиолдолд яаралтай Онцгой байдалын албаруу мэдэгдэн дуудлага өгнө.

9.7 Удаан хугацаагаар цахилгаан тасрах үед Дохиоллын системийн батерейг солих шаардлагатай бол инженер техникийн албаны ажилтан болон итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэдэгдэж батерейг солиулан хэвийн ажиллагааг хангаж ажиллана.

**Арав. Шуурхай бүлэг**

10.1 Шуурхай бүлэг нь операторын өгсөн мэдээллийг хүлээн авмагц уг мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгч, ямар арга тактикаар ажиллах талаар шийдвэр гаргаж, обьектод ирмэгц түргэн шуурхай ажиллана.

10.2 Обьектод гадны хүн нэвтэрсэн тохиолдолд обьектийг бүслэн хааж энэ тухай операторт мэдэгдэн цагдаагийн байгууллагад мэдэгдэхийг сануулж нэмэгдэл хүчийг дуудан ирүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

10.3 Обьектод зэвсэгт дээрэмчид халдсан тохиолдолд бүслэн хааж, ЦБ-ын ажилтнуудыг ирэх хүртэл шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

10.4 Хэрэв обьектод галын аюул учирсан байвал юуны өмнө хүмүүсийг авран хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх ажиллагааг яаравчлан зохион байгуулна.

10.5 Ямар ч үед албаны бэлэн байдлыг хангаж ажиллана.

**Арван нэг. Талуудын эрх, үүрэг**

11.1 <u>Үйлчлэгч талын үүрэг</u>

11.1.1 Гэрээнд заагдсан обьектийг Дохиоллын МБТ-ийн хяналтанд авч, Дохиоллын хамгаалалтын үйлчилгээг үзүүлнэ.

11.1.2 Обьектод халдлага гарсан, гэмт этгээд нэвтрэн орсон тохиолдолд холбогдох арга хэмжээг шуурхай авахын зэрэгцээ энэ тухай үйлчлүүлэгчид яаралтай мэдэгдэн ирүүлж байдлыг газар дээр нь танилцуулна.

11.1.3 Шаардлагатай бүх тохиолдолд цагдаа, гал, эмнэлгийн байгууллагад мэдэгдэж хамтран ажиллана.

11.1.4 Дохиоллын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хянаж, эвдрэл гэмтэл гарсан үед үйлчлүүлэгч талд мэдэгдэж засварлах арга хэмжээ авна. /Баталгаат 1 жилийн хугацаанд гадны нөлөөнөөс бусад техникийн гэмтэл, тохируулгыг үнэ төлбөргүйгээр засварлана./

11.1.5 Үйлчлүүлэгч байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгална.

11.1.6 Үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн ажилтан ажлаас халагдсан тохиолдолд нууц код, түлхүүр үгийг өөрчлөх, мэдээллийг шуурхай солилцох үүрэгтэй.

11.1.7 Үйлчлэгч тал дохиоллын хамгаалалттай холбоотой сургалт, семинарыг улиралд нэг удаа үйлчлэгч талын нийт ажилтнуудыг хамруулан явуулж байна. Шаардлагатай бол үйлчлүүлэгч байгууллагын удирдлагатай хамтран бэлэн байдал бэлтгэгдсэн эсэхийг шалгана.

11.1.8 Нэмэлт тоног төхөөрөмж суурилуулахад, гадны нөлөөнөөс үүссэн гэмтлийг засах зэрэг үйлчилгээний ажлуудыг төлбөртэй гүйцэтгэнэ.

11.1.9 Үйлчлэгч тал хамгаалалтын техникийн болон шуурхай үйлчилгээний дор дурдсан шаардлагыг бүрэн хангах үүрэгтэй.

Үүнд:

a. Дохиоллын систем нь хамгаалж буй обьектийг бүрэн хамрахаар тооцож техник хэрэгслийг тоноглох, байрлалыг сонгох /төслийг хийх/
b. Дохиоллын техник хэрэгслийг /төслийн дагуу/ бүрэн тоноглож, туршиж үйлчлүүлэгч талд ашиглалтанд хүлээлгэн өгөх

c. Дохиоллын техник хэрэгслийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах
d. Байнгын бэлэн байдалд байх

11.1.10 Обьектод түгшүүр дохио дуугарсан тохиолдолд үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо барьж тухайн обьектод очиж шаардлагатай арга хэмжээг авна.

11.1.11 Обьектод түгшүүр дохио дуугарсан тохиолдолд тухайн обьектод очиж шаардлагатай арга хэмжээг авсны дараа обьектод орох зайлшгүй тохиолдолд үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоо барина.

11,1,12 Обьектод түгшүүр дуугарсан тохиолдолд тухайн обьектийг хамгийн сүүлд хамгаалалтанд өгсөн гэрээт хамгаалагчийг заавал байлгана.

<u>Үйлчлэгч талын эрх</u>

11.2.1 Дохиоллын хамгаалалтын нөхцлийг сайжруулахтай холбоотой санал тавих

11.2.2 Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх

11.3 <u>Үйлчлүүлэгч талын үүрэг</u>

11.3.1 Үйлчлүүлэгч нь дохиоллын тоног төхөөрөмжийг зүй ёсоор эзэмшиж, үйлчлэгч талаас өгсөн зааврын дагуу ашиглана.

11.3.2 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж хариуцлагатай ажиллах талаар үүрэг чиг өгч, хяналт тавьж ажиллах

11.3.3 Итгэмжлэгдсэн төлөөлөгч амрах, ажлаас түр чөлөө авах, чөлөөлөгдөх, ажил үйлчилгээний горимд өөрчлөлт орох тохиолдолд үйлчлэгч талд нэн яаралтай мэдэгдэж нууц кодыг өөрчлүүлэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох үүрэгтэй.

11.3.4 Дохиоллын системд гарсан өөрчлөлт эвдрэл гэмтлийн талаар мэдэгдэж засуулах, хэвийн болгох арга хэмжээг яаралтай авах

11.3.5 Дохиоллын системд үйлчлэгч талаас өөр этгээдээр засвар үйлчилгээ хийлгэх, өөрчлүүлэх, салаалуулах, нэмэлт холболт хийлгэхийг хориглоно. Дээрх заалтыг зөрчсөнөөс үүдэн гарах үр дагавар, хариуцлагыг үйлчлэгч тал хариуцахгүй.

11.3.6 Хамгаалуулж буй обьектийн дотор мөнгөн тэмдэгт, үнэт цаас, үнэт эдлэл хадгалах тохиолдолд төмөр сейф /хүндрүүлэгчтэй/-нд хадгалах үүрэгтэй

11.3.7 Хамгаалуулж буй обьектийн хана, тааз, хаалга, цонх, дээврийн хэсэг нь бат бөх түгжээ, цоож, лацтай байх шаардлагыг хангасан байх үүрэгтэй

11.3.8 Үйлчлүүлэгч талаас шаардлагагүй тохиолдолд санаатай буюу санамсаргүйгээр хуурамч дохиолол ирүүлэхгүй байх үүрэгтэй.

11.3.9 Хамгаалагч талын тавьсан санал шаардлагыг тухай бүр хүлээн авч шуурхай шийдвэрлэж хариу мэдэгдэх үүрэгтэй.

11.3.10 Обьектод засвар хийх, эд хогшил тавилга, хана хаалт, лангуу, сурталчилгааны самбар байрлуулах, байрлалыг өөрчлөхөд дохиоллын системийн мэдрэгчүүдийг халхлахаар бол энэ тухай үйлчлэгч талд урьдчилан мэдэгдэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

<u>Үйлчлүүлэгч талын эрх</u>

11.3.11 Дохиоллын тоног төхөөремж болон хамгаалалтын ажиллагааны талаар санал, хүсэлт тавих

11.3.12 Үйлчлэгч тал үүргээ хангалттүй биелүүлж байгаа гэж үзвэл гэрээг цуцлах хүртэл санал тавих

11.3.13 Тусгай карт, нууц түлхүүр үг эзэмшигч итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн, эсвэл бусад этгээдэд мэдэгдсэн тохиолдолд Үйлчлэгч талд энэ тухай нэн даруй мэдэгдэж шинээр нууц код, түлхүүр үг, карт тусгай түлхүүр зэргийг авах

11.3.14 Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх

11.3.15 Гэрээг улирал тутамд дүгнэж гаргасан зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй.

## Арван хоёр. Маргаан шийдвэрлэх журам

12.1 Үйлчлэгч талын үйл ажиллагаатай холбоотой аливаа гомдлыг үйлчлэгч талд хаягаар бичгээр мэдэгдэнэ.

12.2 Үйлчилгээний удирдлага, гомдлыг хүлээн авах шалгалт, судалгаа явуулан авсан арга хэмжээний талаар ажлын 5 хоногийн дотор Үйлчлүүлэгч талд хариу мэдэгдэнэ.

12.3 Ямар нэг маргаантай асуудал гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож эв зүйгээр шийдвэрлэнэ. Тохиролцоонд хүрээгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

## Арван гурав. Талуудын хүлээх хариуцлага

13.1 Обьектод халдлага гарч эд хөрөнгийн хохирол учирсан тохиолдолд 2 талаас магадлах комисс томилж шалтгаан нөхцлийг тогтоосны үндсэн дээр учирсан хохирлыг хэрхэн хариуцах асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв магадлах комисс нэгдсэн дүгнэлт, шийдвэр гаргаж чадаагүйд хүрвэл хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

13.2 Дохиоллын хамгаалалт бүхий обьектийн дотор байгаа эд хөрөнгийг бүхэлд нь эсвэл эд хөрөнгийн зарим хэсгийг лац ломбоор хүлээлцсэн бол лац, ломбоны бүрэн бүтэн байдлыг Үйлчлэгч тал хариуцна.

13.3 Хамгаалуулж байгаа обьектийн доторхи эд хөрөнгийг үйлчлэгч талд тоолж акт үйлдэн хүлээлгэн өгөөгүй тохиолдолд халдлага үйлдэгдэн эд материалын хохирол учирвал 2 тал харилцан ярилцаж хохирол учирсан шалтгаан нөхцлийг тодруулан шалгаж байж асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв үйлчлэгчийн буруутай үйл ажиллагаанаас халдлага гарахад хохирол учирсан бол үйлчлэгч тал хариуцна.

13.4 Байгалийн гамшиг болон бусад нөхцөл байдлын улмаас Үйлчлүүлэгчид хохирол учирсан бол Үйлчлэгч тал хариуцлагаас чөлөөлөгдөнө.
13.5 Байгалийн гамшиг болон давагдашгүй бусад хүчин зүйлээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас дохиоллын тоног төхөөрөмжид эвдрэл гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож уг эвдрэлийг засварлана.
13.6 Гадны этгээдийг обьект дотор үлдээж орхисноос болж гэмт хэрэг, халдлага үйлдэгдсэн бол Үйлчлэгч тал хариуцлагаас чөлөөлөгдөнө.
13.7 Тухайн байгууллагын санхүүгийн бүртгэл тооцоонд ороогүй буюу хувийн эд хөрөнгийг үйлчлэгч тал хариуцахгүй.
13.8 Хэрэглэгч дохиололд телефон утасны шугамаар холбогдохдоо телефон шугам тасралтыг мобикомын GSM-ийн сүлжээг ашиглан мэдэрдэг GSM B3 төхөөрөмжийг суурилуулаагүй тохиолдолд хэрэглэгчийн телефон аппаратын болон кабелийн гэмтэл, телефон ашиглалтын зөрчлийн улмаас үйлчлүүлэгч талаас ямар нэгэн дохио ирээгүй бол хариуцлагыг үйлчлэгч тал хариуцахгүй бөгөөд өөрсдийн боломжоор аюулгүй байдлыг ханган ажиллана.
13.9 Энэхүү гэрээнд заасан обьектийн бэхжилтийн шаардлагыг эс хангаснаас болж халдлага үйлдэгдсэн тохиолдолд Үйлчлэгт тал хариуцлагаас чөлөөлөгдөнө.
13.10 Дохиоллын хамгаалалттай хугацаанд гэмт халдлагын улмаас эд материалын хохирол учирсан, энэ үйлчлэгч талын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж магадлах комисс үзсэн тохиолдолд Үйлчлүүлэгч талд учирсан хохирлыг үйлчлэгч тал бүрэн хариуцна.
13.11 Үйлчлэгч тал дараах тохиолдолд учирсан хохирол, хариуцлагаас чөлөөлөгдөнө.
Үүнд:

1. Байгалийн гэнэтийн аюул гамшиг, гал түймрийн улмаас эд материалын хохирол учирсан бол
2. Үйлчлүүлэгч тал энэхүү гэрээний 11.3.7-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас хохирол учирсан
3. Халдлагын ул мөрийг үйлчлүүлэгч тал санаатай буюу санамсаргүйгээр арилгасан
4. Үйлчлүүлэгч тал энэхүү гэрээний 11.3.9, 11.3.10-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас хохирол учирсан
5. Гадны халдлагын улмаас хамгаалуулж буй обьектийн хаалга, цонх, хамгаалалтын төмөр хаалт, хагарсан, цуурсан, эвдэрч хэмхэрсэн тохиолдолд
6. 14.2-т заасан үүргээ биелүүлсэн
7. Дохиололын тоног төхөөрөмж хэвийн ажилласан
8. Радио долгионы төхөөрөмж суурилуулагдаагүйгээс болж объектоос телефон утас тасарсан дохио ирээгүйгээс халдлага болсон тохиолдолд

13.12 Үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч үйлчлэгт талд обьектийг хүлээлгэн өгөхдөө обьект доторхи сейф, лац, ломбо, эд хогшлыг бүхэлд нь тоолж хавсралт 1,2-т заасан актыг хүлээлгэн өгнө.
13.13 Обьектийг хүлээлцэх актад дараах зүйлүүдийг заавал тусгана.
Үүнд:

1. Хамгаалалтанд хүлээлцэж байгаа обьектийн нэр, зэрэглэл, ажил үйлчилгээний төрөл, талбайн хэмжээ, байрлал
2. Хамгаалалтанд байлгах дэг журам, хамгаалалтанд хүлээлгэн өгсний дараа харилцан ажиллах хүн, нууц түлхүүр, харилцах арга зам
3. Обьектод радио дохио дамжуулагч тавигдсан эсэх, тавигдсан бол үүнийг ашиглахад 2 талын харилцан хүлээх үүрэг, радио дамжуулагчийг үрэгдүүлэхгүй, гэмтээхгүй байх үүрэг хариуцлага зэрэг болно.

13.14 Үйлчлүүлэгч тал үйлчлэгч талаас бичгээр зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд өөрийн хүчээр болон гуравдагч этгээдээр системийг өөрчлүүлэх, салаалуулах, нэмэлт холболт хийлгэх эрхгүй. Үүнийг зөрчсөнөөс системийн үйл ажиллагаанд гарсан хариуцлагыг үйлчлэгч тал хариуцахгүй.
13.15 Үйлчлүүлэгч тал сарын үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдол дохиолол хамгаалалтыг хэсэгчлэн буюу бүрэн зогсоох бөгөөд үүнээс гарах үр дагаврыг үйлчлэгч тал хариуцахгүй болно.

## Арван дөрөв. Бусад зүйлс

14.1 Обьектоос түгшүүрийн дуудлага авах тохиолдолд өвөл зуны улирал буюу өдөр шөнийн цаг, замын ачаалал обьектод хүрэх зайг харгалзан үзэж хугацааг тогтоох ба зайлшгүй шаардлагатай гэсэн тохиолдолд үйлчлүүлэгч талын төлөөлөгчийг байлцуулан туршилтын журмаар шуурхай бүлгийн машинаар явж хугацааг тогтооно.
14.2 Хүрэх хугацааг өдрийн цагаар / 08:00-21:00 цагийн хооронд/ - 8 минутын дотор, оройн цагаар /21:00-08:00 цагийн хооронд/ - 6 минутын дотор гэж талууд тохиролцон тогтоов.

14.3Баталгаат хугацаа дууссанаас хойш гарсан гэмтэл, эвдрэлийг засах, солих, цэвэрлэгээ үйлчилгээг үйлчилгээний тогтоосон үнэлгээний дагуу хийж гүйцэтгэнэ.

14.4 Аль нэг талын зөвшөөрөлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага мэдээлэл өгөхгүй байна.

14.5 Ажлын бус цагаар 1-р хэрэглэгч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ -ээс өөр хэрэглэгч обьектод нэвтрэхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд 1-р хэрэглэгчээс зөвшөөрөл авна.

14.6 Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт тодотгол оруулж болох бөгөөд тэдгээрийг 2 тал харилцан тохиролцож протокол үйлдэнэ. Тэдгээр нэмэлт өөрчлөлт тодотгол нь энэхүү гэрээний салшгүй хэсэг мөн.

14.7 Гэрээний ерөнхий хугацаа дуусахад гэрээг цуцлах талаар талууд санал ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

14.8 Гэрээ нь 2 хувь үйлдэгдсэн бөгөөд Талуудын байгууллагын нууцад хамааргадана. Бусдад танилцуулах, шилжүүлэх, мэдээлэхийг хориглоно.

**<u>Талуудыг төлөөлж:</u>**

| | |
|---|---|
| "ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН " ГАЗРЫН НЯГТЛАН БОДОГЧ | "ДАРХАН СЕКЬЮРИТИ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР |
| ........................../Д.ЦОГБАЯР / | ........................../ Ч.НЯМХҮҮ / |
| Утас:99013355 | Утас: 70378408 99135091 |
| Дархан-Уул аймаг | Дархан сум 10-р баг 380-н 80 тоот |

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2025 оны 05 сарын 02 өдөр    Дугаар А/27    Дархан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйл 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4 , 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Дархан сумын 2025 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжих "ЗДТГ-ын засвар" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Д.Жамбалдорж | Дархан-Уул аймгийн Музейн захирал |
| Гишүүд: | С.Хишигбаяр | "Улаанбаатар гурил" ХХК-ийн эрүүл Ахуйч |
| Нарийн бичиг: | Б.Эрдэнэцэцэг | Дархан сумын ЗДТГ-ын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн |

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Жамбалдорж)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулж, Тамгын газрын Даргын 2025 оны 03 сарын 11-ний өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТАМГЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ    Ц.АМАРЗАЯА

D:Ajil.tushaal-2025

4525030169

"ДМАС" ХХК-Д

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Өргөө баг, Дархан сум, Дархан-Уул аймаг 45040
Утас/факс: (976) 7037-7840
Цахим шуудан: da.darkhan.sum@gmail.com
Цахим хуудас: Darkhan.da.gov.mn

2025.05.19 № 03/602

танай ________________-ны №________________-т

Гэрээ байгуулах эрх олгох тухай

***[ЗДТГ-ын засвар (Багийн төвүүдийн тохижилтын ажил), ДУАДАСЗДТГ/20250201006]***-ийн тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгож буйг үүгээр мэдэгдэж байна..

Гэрээний үнэ: **79,000,335.0 /Далан есөн сая гурван зуун гучин тав/** төгрөг

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 05 дугаар сарын 21-ний өдрийн дотор худалдан авах гэрээг баталгаажуулж ирүүлнэ үү.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.АМАРЗАЯА

4525030019

**ДАРХАН - ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР ОНӨААТҮГазар**

Дархан сум, Дархан-Уул аймаг
Утас: (976) 7708-5888
Цахим шуудан: Barilga@da.gov.mn
Цахим хуудас: https://bzg.da.gov.mn

2025.07.31 № 01/390

танай ______________-ны № ______________-т

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

"ДМАС" ХХК-ийн ОНТС/2025-02 дугаартай гэрээгээр гүйцэтгэсэн "Багийн төвийн засвар, тохижилтын ажил (Дархан сум, Малчин баг)"-нь 100%-ийн гүйцэтгэлтэй тул барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулж өгнө үү.

ДАРГА Д.БАТБАЯР

452520390

*D.BZ-2025 toot-A5*

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Өргөө баг, Дархан сум, Дархан-Уул аймаг 45040
Утас/факс: (976) 7037-7840
Цахим шуудан: da.darkhan.sum@gmail.com
Цахим хуудас: Darkhan.da.gov.mn

2025.05.19 № 03/602

танай ____________-ны №____________-т

"ДМАС" ХХК-Д

Гэрээ байгуулах эрх олгох тухай

***[ЗДТГ-ын засвар (Багийн төвүүдийн тохижилтын ажил), ДУАДАСЗДТГ/20250201006]***-ийн тендер шалгаруулалтад ирүүлсэн танай тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгож буйг үүгээр мэдэгдэж байна..

Гэрээний үнэ: **79,000,335.0 /Далан есөн сая гурван зуун гучин тав/** төгрөг

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 05 дугаар сарын 21-ний өдрийн дотор худалдан авах гэрээг баталгаажуулж ирүүлнэ үү.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.АМАРЗАЯА

**БАТЛАВ**

**ЗАХИАЛАГЧ:**
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.АМАРЗАЯА

**ГҮЙЦЭТГЭГЧ:**
ДМАС ХХК-ИЙН ЗАХИРАЛ
М.АЛТАНСҮХ

# БАГИЙН ТӨВИЙН ЗАСВАР, ТОХИЖИЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

(Дархан сумын ЗДТГ)

2025.05.21 Дугаар: №ОНТС/2025-02 Дархан сум

Нэг талаас ***(Дархан сумын ЗДТГ, РД:9022465)*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ***(ДМАС ХХК, РД:4257855)*** (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үнэ нь ***79,000,335.0 (далан есөн сая гурван зуун гучин тав)*** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг гүйцэтгэгч ***ДМАС*** харилцах ***Голомт банк 4305010704*** дугаартай дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох шийдвэр;
   - 3.2. Гэрээ баталгаажуулах маягт;
   - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.5. Техникийн тодорхойлолт;
   - 3.6. Ажил гүйцэтгэх хуваарь;
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   - 4.1 Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг /эх/-ийн нэр: Цогт
     Нэр: Янжиндулам
     Албан тушаал: Мэргэжилтэн
     Ажлын утас: 70373005
     Гар утас: 94648008,89640808
     Цахим шуудан: da.darkhan.sum@gmail.com
   - 4.2 Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх/-ийн нэр: Митя
     Нэр: Алтансүх
     Гар утас:94949120
     Хаяг: 14 дүгээр баг, 6 дугаар барилга
5. Санхүүжилтийн хувиар: Ажлын гүйцэтгэлээр 80% хүртэл хувийн санхүүжилт олгоно. Гүйцэтгэгч байгууллага нь ажил бүрэн гүйцэтгэж дууссаны дараа гүйцэтгэлийн тайлан, хүлээн авах комиссын акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг олгоно.

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

**Тодорхойлолт**

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. "Захиалагч" гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.2. "Захиалагчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.3. "Гүйцэтгэгч" гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. "Гүйцэтгэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.5. "Талууд" гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6. "Хууль" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. "Ажил" гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.8. "Ажлын талбай" гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;

1.1.9. "Баталгаат хугацаа" гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;

1.1.10. "Гомдлын шаардлага гаргах хугацаа" гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

**Тайлбар**

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн

тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ

**Захиалагчийн нийтлэг үүрэг**

2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.

2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

**Захиалагчийн төлөөлөгч**

2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.

2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

**Талбайд нэвтрэх зөвшөөрөл**

2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.

2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

**Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг**

3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.

3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.

3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг а талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.

**Гүйцэтгэгчийн төлөөлөгч**

3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.

3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

**Техникийн болон ажлын талбайн өгөгдөл**

3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.

**Ажлын талбайн харуул хамгаалалт**

3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.

3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.

**Хог, хаягдал ба нөхөн сэргээлт**

3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.

3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.

3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.

**Археологийн болон бусад олдвор**

3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.

**Аюулгүй байдал**

3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.

3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.

3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холб... үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.

3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.

3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

**Ажил эхлэх**

4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

**Хугацаа сунгах**

4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;

4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;

4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.

4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.

4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

**Ажлын явцын тайлан**

4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.

4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажил[illegible] техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ

5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.

5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

Урьдчилгаа төлбөр

5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.

5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.

Төлбөрийн нөхцөл

5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.

5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

Урьдчилгаа төлбөрийн баталгаа

6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалт улмаас гүйцэтгээгүй;

6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.

Чанарын баталгаа

6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.

6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.

6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.

6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Баталгаат хугацаа

6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.

6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

## ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

Бусдад учруулсан хохирлыг арилгах

7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.

Захиалагчийн хүлээх эрсдэл

7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;

7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн б захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;

7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.

7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

Даатгал

